



МОНГОЛ УЛС
ХЭНГИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 08 сарын 05 өдөр

Дугаар А/339

Чингис хот

Тусгай зөвшөөрөл олгох, сунгах,
хүчингүй болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.5ын "а,г", Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1, 19.2, 19.3.2, 19.3.5, 19.20.1, 19.20.5, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.2, 10 дугаар зүйлийн 10.1.1, 10.1.5, 12 дугаар зүйлийн 12.1, 14 дүгээр зүйлийн 14.1.4, 16 дугаар зүйлийн 16.2, 16.2.2, Захиргааны ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.3, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Тэргүүлэгчдийн хурлын 2018 оны 53 дугаар тогтоолын 5.8 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Эрүүл мэндийн байгууллагад мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл олгох комиссын 2020 оны 07 дугаар сарын 28-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн Батширээт суманд үйл ажиллагаа явуулж буй "Аралтай онон" эмийн сан, Цэнхэрмандал суманд үйл ажиллагаа явуулж буй "Хаан дом" эмийн сангийн эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийн хугацааг тус тус 1 жилийн хугацаатай сунгасугай.

2. Хэрлэн суманд үйл ажиллагаа явуулах МЭИК ХХК-ний эм ханган нийлүүлэх төвийн эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 3 жилээр, Бор-Өндөр суманд үйл ажиллагаа явуулах "ЭЭС БОДЬ" ХХК-ний эмийн сан, Хэрлэн суманд үйл ажиллагаа явуулах "Хайрхан тун" ХХК-ний эм ханган нийлүүлэх төвийн эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 2 жилийн хугацаатай тус тус шинээр олгосугай.

3. Бор-Өндөр суманд үйл ажиллагаа явуулж буй "Оточ мэнд" хүүхдийн клиник, Баянмөнх суманд үйл ажиллагаа явуулж буй "Агаарын тунгалаг" уламжлалтын клиник, Хэрлэн суманд үйл ажиллагаа явуулж буй "Анир" чих, хамар, хоолойн клиник, Хэрлэн суманд үйл ажиллагаа явуулж буй "Саран дент" шүдний клиник, Хэрлэн суманд үйл ажиллагаа явуулж буй "Моньс" эмийн сан, Өмнөдэлгэр суманд үйл ажиллагаа явуулж буй "Оорцог бүрд" эмийн сан, Цэнхэрмандал суманд үйл ажиллагаа явуулж буй "Алтан

2.

хундага” эмийн сангийн эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 2020 оны 08 дугаар сарын 03-ны өдрөөс эхлэн хүчингүй болгосугай.

4.Дээрх эмийн сан, эм ханган нийлүүлэх байгууллага, рашаан сувиллын үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн газрын дарга /Ц.Гэрэлмаа/- д даалгасугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн байгууллагад мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл олгох комиссын дарга бөгөөд аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга /Г.Лхагвахатан/- д үүрэг болгосугай.

6. Энэхүү захиргааны актыг хүлээн зөвшөөрөхгүй тохиолдолд албан ёсоор гардаж авснаас хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх эрх бүхий байгууллагад гаргах эрхтэй болохыг дурдсугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА